



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 11 өдөр

Дугаар A/103

Улаанбаатар хот

┌ **Ажил гүйцэтгүүлэх тухай** ─┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.14 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1.8 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Цаг агаарын нөхцөл байдал хүндэрсний улмаас дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын байгууллага, хорооны цогцолбор байрны шугам сүлжээ, инженерийн байгууламж хөлдөх, лаг бохирт бөглөрөх гэмтэл гарч байгаа тул яаралтай арга хэмжээ авч, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажлыг хийж гүйцэтгүүлсүгэй.

2.Инженерийн шугам сүлжээний засварын ажлыг өндөр түвшинд хийж, гүйцэтгэхийг Захиалагчийн алба ОНӨААТҮГ (Д.Алтанхуяг)-т даалгасугай.

3.Тус ажилд шаардагдах зардлыг тухай бүрд нь гүйцэтгэлээр Хот тохижуулах зардлаас санхүүжүүлэхийг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Менежер (Д.Баярсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТТӨР

